

**Дуу хөгжмийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг  
харьцуулан судалсан зарим үр дүнгээс  
(МУБИС болон ӨМБИС-ийн хөтөлбөрийн жишээн дээр)**

Э.Мандалт<sup>а</sup>, Я.Шийлэгмаа<sup>\*б</sup>

<sup>а</sup>Өвөр Монголын Багшийн Их Сургууль, Урлагийн дээд сургууль,  
Язгуур урлагийн тэнхим

<sup>б</sup>Монгол Улсын Боловсролын Их Сургууль,  
Эрдэм шинжилгээ, инновацийн алба

## Хураангуй

Дуу хөгжмийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэхдээ боловсролын орчин үеийн онол, урсгал, үнэт зүйлсийг сургалтын хөтөлбөрийн зорилго, бүтэц, агуулгыг тодорхойлоход харгалзсан байх, хөтөлбөр боловсруулахдаа ямар онол, үзэл баримтлалыг баримжаалан боловсруулсан асуудлыг судлах нь чухал болно.

Бид судалгааны ажлын хүрээнд ӨМБИС болон МУБИС-ийн дуу хөгжмийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг харьцуулан судалж, хоёр хөтөлбөрийн ижил болон ялгаатай тал, давуу сул талыг судалсны үндсэн дээр боловсруулалтыг чанарыг шалгуурын дагуу үнэлсэн болно. Түүнчлэн хөтөлбөрийн онол, аргазүй, чиг хандлагыг судлах, хөтөлбөрийг үнэлэх загвар, аргазүйн хувилбар боловсруулах, хоёр хөтөлбөрийн боловсруулалтын харьцуулсан судалгаа, үнэлгээ дүгнэлт хийх, дуу хөгжмийн судлан буй хоёр хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, үр дүнгийн хамаарлын тодорхойлсон байдлыг үнэлэх, харьцуулалт хийх, агуулга, аргазүйн харьцуулсан судалгаа хийх, үнэлгээний тогтолцоо болон хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, чанарыг баталгаажуулах тогтолцоо, хөтөлбөрийн бичиг баримтад хэрхэн туссан тухай харьцуулах, сул тал болон эрсдэлийг нөхөх, боломж болон давуу талыг улам сайжруулах стратеги боловсруулах, санал зөвлөмж гаргах гэх мэтээр олон зорилтыг хэрэгжүүлсэн судалгааны ажлуудыг хийлээ. Бид энэ ажлаар хамтын ажиллагаатай 2 сургуулийн сургалтын хөтөлбөр боловсруулахад баримталж буй тушаал шийдвэр, хөтөлбөрийн зорилго зорилт, зарчим түүнийг хязгаарлаж буй эсэх, улмаар дэлхий нийтийн өнөөгийн хандлагатай хэрхэн уялдаж буй байдлыг судлан тодорхойлов. Өнөөдөр их сургуулиуд зөвхөн хөтөлбөрийн төлөвлөлтөд анхаарч цаасан дээр хөтөлбөрөө боловсруулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх (сургалтын өдөр тутмын хяналт, багшийн заах арга зүй), төлөвлөж, хэрэгжүүлж буй хөтөлбөрийг оюутан хэрхэн эзэмшсэнийг үнэлэх үнэлгээ хоёрыг орхигдуулах хандлагатай байна хэмээн дүгнэж байна.

## Түлхүүр үг

Хөгжмийн боловсрол, мэдлэг, чадвар, хандлага, хөгжил, төлөвшил, үр дүн, хичээлийн хөтөлбөр, үнэлгээ, стандарт

## Удиртгал

Бидний судлан буй их сургуулийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл нь зөвхөн хөтөлбөрийн шинэчлэл төдийхнөөр хязгаарлагдах уу? эсвэл дээд боловсролыг бүхэлд нь шинэчлэх үү? гэсэн асуултад хариулахад эрт байгаа хэдий ч хөтөлбөрийн харьцуулсан судалгааг хийсний үндсэн дээр судлан буй хоёр хөтөлбөрийн давуу, сул тал, ижил болон ялгаатай талыг илрүүлэн, түүндээ үндэслэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлага байсаар байна. Өдгөө боловсролын салбарт ихээхэн шинэчлэл хийгдэж байгаа

хэдий ч Монгол улс болон БНХАУ-ын “дуу хөгжим” мэргэжлийн бакалаврын хичээлийн хөтөлбөрийг харьцуулсан тусгайлсан судалгаа байхгүй байна. Хөтөлбөрийн талаар профессор Ц.Лувсандорж “Хичээлийн хөтөлбөр нь судлах агуулгын дидактик хувиргалт, сэдвийн дидактик шийдлийг тээгч баримт бичиг байдаг бол хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт болох хичээл нь багшлах ухаан, багшлах урлаг болж харагдах онцгой эгшин” хэмээн тодорхойлсон байна (Лувсандорж, Дуламсүрэн, 2018, х.8).

Доктор Ж.Даваа бүтээлдээ “Сургалтын

\*Холбоо барих зохиогч: Shiilegmaa@msue.edu.mn

хөтөлбөр нь шийдвэр гаргах үйл явц бөгөөд хэрэгжилтийн явцад өөрчлөгдөж боловсронгуй болдог үйл явц юм. Сургалтын хөтөлбөр нь үр дүн гэж үзвэл дүн шинжилгээ, хүний нөөц, хөтөлбөрийн менежмент зэрэг асуудлыг багтаасан бодлогын баримт бичиг юм” (Даваа, 2012.х.19) хэмээжээ.

Иймээс дээрх хичээлийн хөтөлбөрүүдийг улам чанаржуулах үүднээс МУБИС-ийн багш, урлагийн боловсрол, ӨМБИС-ийн “хөгжим судлал” мэргэжлийн бакалаврын хичээлийн хөтөлбөрийн өнөөгийн байдлыг харьцуулан судлах нь чухал ач холбогдолтой хэмээн үзсэн юм. Бидний шинээр боловсруулах хичээлийн хөтөлбөр нь арга зүй талаасаа хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлох, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын үнэлгээг төлөвлөх, эдгээрийн хоорондын хамаарлыг гаргах гэсэн хэсгүүдээрээ өмнө хэрэглэж ирсэн хичээлийн хөтөлбөрөөс ялгаатай. Сургалтын үр дүн нь суралцагчдын болон нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй багш нар өөрийн чадамжаас хамааран сургалтын хөтөлбөрийг янз бүрээр боловсруулж байгаа нь хичээлийн үнэ цэнийг бууруулах, оюутанд цогц, мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлж чадахгүй байгаа тул асуудлыг нарийвчлан тодруулах улмаар шийдвэрлэх боломжийг эрэлхийлэн судлав. Дээд боловсролын шинэчлэлийн бодлоготой уялдуулан хөтөлбөрийг боловсруулах нь сургалтын чанар сайжрах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дуу хөгжмийн багш бэлтгэх боломжийг бүрдүүлэх тул энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийсэн үр дүнгээ танилцуулах болно.


### Судалгааны арга зүй

Дуу хөгжмийн салбарын оюутан суралцах 3-6 жилийн хугацаандаа ерөнхий суурийн 20, мэргэжлийн сонгон 42, мэргэжлийн 63 кредит, дадлага 15 кредит нийт 140 кредит судлахаар төлөвлөсөн байна. ӨМБИС-ийн сургалтын журамд бакалаврын хөгжмийн боловсролын ангийн сургалтын нийт кредитийг 140-өөс хэтрүүлж болохгүй хэмээн заажээ. Гэвч салбар, мэргэжил бүрийн онцлогоос шалтгаалан кредитийн дээд хэмжээ 140-160 хүртэл өөр өөр байдаг бөгөөд гадаад хэл, биеийн тамир, дуу, урлаг зэрэг мэргэжлийн хөтөлбөрийн нийт кредит 160-аас хэтэрч болохгүй хэмээн заасан байдаг. Тухайн оюутан 7 төрлийн 15 кредитийн дадлага ажлыг гүйцэтгэх бөгөөд судлах дадлага, танилцах дадлага, мэргэжлийн дадлага, төгсөх дадлага, дадлагын тайлан, шинийг санаачлах /

инноваци/ дадлага зэргийг өөрийн мэргэжлийн чиглэлээр эрдэмтэн судлаач, багш сурган хүмүүжүүлэгч, ардын авьяастан, хувь хүмүүсээс сурвалжлан урлагийн тулгамдсан асуудлыг дэвшүүлэх, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн гүйцэтгэдэг байна. Мөн цэргийн боловсрол хичээлийг практикаар судалж тооцуулсан байна. Оюутан бүр жилд бие даан буюу хамтарч тайзны урлагийн тоглолтод оролцсон байх ба 4 жилийн хугацаанд тоглолтод 3-аас дээш удаа оролцсон байна. хэмээн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан нь оюутныг бие даан дадлагажуулах ач холбогдолтой хэмээн дүгнэж болно. Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Хөгжмийн дээд сургуулийн дуу хөгжмийн багшийн сургалтын төлөвлөгөөний бүтэц дэх цагийн хувийг нэгтгэж үзвэл:

Диаграмм 1

ӨМБИС-ийн дуу хөгжмийн сургалтын төлөвлөгөөний кредит болон хувийн харьцаа




Эх сурвалж, ӨМБИС. (2016). Хөгжим судлалын бакалаврын сургалтын хөтөлбөр. Хөххот.х.29-56

Дүгнэлт: Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Хөгжмийн дээд сургуулийн дуу хөгжмийн багшийн сургалтын төлөвлөгөөний агуулгад 4 жилдээ нийт 140 кредит судалж байгаа нь МУБИС-ийн багш, урлагийн боловсролын хөтөлбөрийн агуулгаас 16 кредитээр илүү /17.3%/ байна. МУБИС-ийн сонгон судлах хичээл нь 12 кредит 14% байхад ӨМБИС-ийн хөтөлбөрт 42 буюу 30 % байгаа нь оюутан өөрийн сонголтоор бие дааж хөгжих, чадваржих боломжид илүү анхаарч, төлөвлөдөг байна.

Диаграмм 2

ӨМБИС-ийн дуу хөгжмийн сургалтын төлөвлөгөөний нэгдсэн үзүүлэлт



МУБИС-ийн багш урлагийн боловсролын сургалтын хөтөлбөр

Хүснэгт 1

МУБИС-ийн Сургалтын төлөвлөгөөний кредитийн хуваарилалт

| Хичээлийн төрөл        |                                         | Заавал судлах хичээл |       | Сонгон судлах хичээл |      | Нийт судлах хичээл |       |
|------------------------|-----------------------------------------|----------------------|-------|----------------------|------|--------------------|-------|
|                        |                                         | кредит               | хувь  | кредит               | хувь | кредит             | хувь  |
| Ерөнхий суурь          |                                         | 21                   | 17%   | 4                    | 3.2% | 25                 | 20.2% |
| Багш боловсролын суурь |                                         | 17                   | 13.7% | 2                    | 1.6% | 19                 | 15.3% |
| Мэргэжлийн хичээл      | Мэргэжлийн хичээл                       | 74                   | 59.7% | 4                    | 3.2% | 78                 | 62.9% |
|                        | Дипломын ажил бичих, төгсөлтийн шалгалт | 2                    | 1.6%  | 0                    | 0    | 2                  | 1.6%  |
| нийт кредит 124        | Нийт                                    | 114                  | 91.9% | 10                   | 8.1% | 124                | 100%  |

Эх сурвалж: МУБИС-ийн багшийн сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн ажлын тайлан. Хөтөлбөр суурьтай хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн. (2018)УБ. х.24-26

### Судалгааны үр дүн

Урлагийн боловсролын сургалтын төлөвлөгөөний кредитийг харьцуулж үзвэл нэлээд зөрүү гарч байна. Тухайлбал, ӨМБИС-ийн хөгжмийн боловсролын бакалаврт суралцагч нь нийт 140 кредит судалж байхад МУБИС-ийн суралцагч нийт 124 кредит судалдаг байна. Нийт 16 кредитийн зөрүүтэй, харин ӨМБИС-д сонгон суралцах кредит 42 кредит 30% бол МУБИС-д 10 кредит 0.08% буюу 32 кредитийн зөрүүтэй байна. Сургалтын төлөвлөгөөний кредитийн бүтцийг эзлэх хувийн жингээр харьцуулж үзвэл ӨМБИС-д ерөнхий суурь хичээл 14% бол МУБИС-д 20.1%, МУБИС-д багш мэргэжлийн суурь хичээл 15.3% бол ӨМБИС-д багш мэргэжлийн суурь хичээл ордоггүй онцлог талтай. МУБИС-д мэргэжлийн заавал судлах хичээл 53%, мэргэжлийн хичээл 45% байна. Эндээс үзэхэд ӨМБИС-д хөгжмийн боловсролын хөтөлбөр МУБИС-аас 16 кредитийн нэмэлт хичээл судалдаг байна. Багш боловсролын дадлага МУБИС-д 13 кредит буюу 10.4%, ӨМБИС-д 15 кредит буюу 11%

байна. Эндээс харвал ӨМБИС-д сонгон судлах 32 кредитээр, дадлага 2 кредитээр илүү судалж байгаа нь мэргэжлийн чадвар олгох хичээл илүү орж байгаа нь ажиглагдаж байна. МУБИС-д багш боловсролын суурь хичээл орж байгаа нь оюутан багшлах үйл явцад мэдлэг чадвар олгож байгаа нь хэрэгжүүлж болмоор туршлага хэмээн үзэж байна.

Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн нэрсийн хувьд харьцуулж үзвэл ерөнхий суурь хичээлүүд 2 сургуулийн сургалтын хөтөлбөрт ойролцоо тусгагдсан, харин мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийн нэрсийн хувьд нэлээд зөрүүтэй байна. Тодруулбал, ӨМБИС-д кино телевизийн бүтээлийн шүүмж, театрын хөгжмийн бүтээлийг судлан шинжих нь, дотоод гадаадын оркестр, хөгжмийн бүтээлийн судалгаа, барууны дуулалт жүжгийн судалгаа, зөв дуудлага, удирдаачийн ур чадвар, инноваци шинэ бүтээл зэрэг өвөрмөц нэршилтэй хичээлүүд тусгагдсан байна. Харин МУБИС-д найрал хөгжим, ардын хөгжим, хөгжимт хөдөлгөөн заах арга зүй, дуурьсахуйн ухаан, язгуур урлаг, нумт чавхдаст хөгжим, цахилгаан хөгжим зэрэг ялгаатай нэршил бүхий хичээлүүд тусгагджээ. Эндээс үзэхэд ӨМБИС нь 16 кредитийн илүү хичээл судалдаг тул хичээлийн нэрс болон тооны хувьд МУБИС-аас нэлээд их байгаа нь ажиглагдсан.

Хичээлийн зорилгын хувьд харьцуулбал ижил төсөөтэй талууд нь бүтээлч сэтгэлгээгээр дуу хөгжмийн сургалтыг явуулах төлөвшил бүрэлдүүлэх, дунд сургуулийн хөгжмийн хичээлийн хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэх арга барилд суралцуулах, хөгжмийн сургалтын үндсэн онолыг эзэмшүүлэх юм. Харин ялгаатай талууд нь хичээлээр дамжуулан суралцагсдыг дуу хөгжмийн сургалтын үйл хэрэгт сонирхон дурлуулах, судалгааны материал үзэж судлан асуудлыг олж харах, шийдвэрлэж сурах, хөгжмийн боловсролын сургуулийн сургалтад эзлэх байр суурь, нөлөөллийг тодорхойлж сургуулийн хөгжмийн боловсрол олгох сургалтын зорилго, чиг үүрэг, хэрэгцээг ойлгуулж, бага дунд сургуулийн хөгжмийн сургалтын онол, практикийн түүхэн өөрчлөлт хөгжил, дотоодын хөгжмийн боловсролын хичээлийн хувьсал өөрчлөлтийн судалгааны үр дүнг таниулан ойлгуулж сургалт болон судалгааны мэдлэгийг нэмэгдүүлэх, боловсрол судлалын онол, аргазүй, хөгжмийн боловсролын мэдлэг, чадвартаа тулгуурлан хөгжмийн боловсролын стандарт, үндэсний хөтөлбөр болон сурах бичиг ашиглан

сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэн суралцах юм.

Хичээлийн зорилт, үндсэн шаардлагын хувьд харьцуулбал ижил төсөөтэй талууд нь хөгжмийн боловсролын заах арга зүйн үндсийг эзэмшүүлэх, дуу хөгжмийн сургалтын ухагдахуун, тодорхойлолт, зарчмыг тодорхой хэмжээгээр тусгаж сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, сурагчийн сурах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, үнэлэх чадвартай байна. Харин ялгаатай талууд нь цахим хэрэглэгдэхүүн бүрэн гүйцэт ашиглан сургалтыг хялбаршуулах, онолын агуулгаас гадна хөгжмийн сургалтын заах арга зүйг эзэмшүүлэх, тасралтгүй хөгжих чадвартай багшийг бэлтгэнэ.

Хичээлийн агуулгын хувьд харьцуулбал ижил төсөөтэй талууд нь хөгжмийн сургалтын үндсэн ойлголт, хөгжмийн хичээлийн зорилго, бэрхшээл, хөгжмийн хичээлийн агуулга, хөгжмийн сургалтын сурах бичгийн судалгаа, сургалтын хөтөлбөр, хөгжмийн сургалтын явцын үндсэн элемент, тэдгээрийн харилцан уялдаа холбоо, хөгжмийн сургалтын хэлбэр, ангилал, хөгжмийн сургалтын үнэлгээг хэрэгжүүлэх, орчин цагийн хөгжмийн боловсролын ойлголтууд зэрэг багтана. Харин ялгаатай талууд нь бага байна.

Бид судалгааны ажилдаа хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг хэмжээсжүүлэн үнэлэх арга, аргачлалыг үндэслэн ӨМБИС, МУБИС дуу хөгжмийн хичээлийн хөтөлбөрийг үнэлсэн болно (Дуламсүрэн, 2018, х.108,109). Судалгааны ажлын хүрээнд хөтөлбөрийн чанарыг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн үндсэн бүтцэд тулгуурлан 5 шалгуур бүрээр нийт 75 оноог бүрдүүлэх бөгөөд нэг үзүүлэлтэд 0-5 оноогоор тооцож үнэлгээжүүлсэн болно.

#### Шалгуурын онооны үнэлгээний утга

| Оноо | Шалгуурын үнэлгээ  |
|------|--------------------|
| 5-4  | Бүрэн хангасан     |
| 3-2  | Хэсэгчлэн хангасан |
| 1-0  | Хангаагүй          |

Бидний судалгааны ажлын хүрээнд сонгон авсан эхний буюу хичээлийн боловсруулалтын чанарыг үнэлэх шалгуур шаардлага нь МУБИС-ийн 50 хөтөлбөрүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч үнэлгээ хийсэн бөгөөд докторын судалгааны ажлын хүрээнд магадлалт чанар нь батлагдсан болно. Бид судалгааны ажлын найдвартай чанарыг хангах үүднээс 2 дахь шалгуурыг буюу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн

сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ӨМБИС, МУБИС, Сайжруулан боловсруулсан хөтөлбөрүүдийг үнэлсэн болно.

Бид хөтөлбөрийн боловсруулалтын байдлыг үнэлэх зорилго тавьсан тул 2 дахь шалгуур буюу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурын дагуу үнэлэхдээ нийт 7 шалгуураас хөтөлбөрийн төлөвлөлт, хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл, сургалтын үйл ажиллагаа зэрэг боловсруулалтын байдлын үнэлэх боломжтой 3 шалгууруудыг сонгон авч үнэлсэн болно. Магадлан итгэмжлэлийн шалгуураар үнэлгээг үнэлэхдээ бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй гэсэн үнэлгээг өгдөг бөгөөд бид боловсруулалт хийх үүднээс 0-5 хүртэлх оноог өгч үнэлсэн болно.

Шалгуур 1 болон 2-оор үнэлсний дараа шалгуур тус бүрийн болон нэгдсэн үнэлгээг гаргаж, өгөгдлийн боловсруулалт шинжилгээг хийв. Шалгуурын үнэлгээ хийхдээ гол баримталсан зарчим нь төлөвлөлт/хандлага, хэрэгжилт/үр дүн, үнэлгээ/дүгнэлт, сайжруулалт/хөгжүүлэлт хэмээн үнэлсэн болно.

#### Хүснэгт 2

Сургалтын хөтөлбөрийн боловсруулалтын чанарыг хэмжээсжүүлэн үнэлэх шалгуур

| Шалгуур                                       | ӨМБИС<br>(оноо)      | МУБИС<br>(оноо)      |
|-----------------------------------------------|----------------------|----------------------|
| 1-р шалгуур<br>Хөтөлбөрийн зорилго,<br>зорилт | 55                   | 71                   |
| 2-р шалгуур<br>Хөтөлбөрийн агуулга            | 53                   | 67                   |
| 3-р шалгуур<br>Хөтөлбөрийн арга зүй           | 44                   | 55                   |
| 4-р шалгуур<br>Сургалтын хэрэглэгдэхүүн       | 30                   | 48                   |
| 5-р шалгуур<br>Хөтөлбөрийн үнэлгээ            | 15                   | 38                   |
| Дундаж оноо                                   | 197 оноо<br>буюу 52% | 279 оноо<br>буюу 74% |

| Шалгуур                                       | ӨМБИС<br>(оноо) | Сайжруулсан<br>хөтөлбөр<br>(оноо) |
|-----------------------------------------------|-----------------|-----------------------------------|
| 1-р шалгуур<br>Хөтөлбөрийн зорилго,<br>зорилт | 55              | 71                                |
| 2-р шалгуур<br>Хөтөлбөрийн агуулга            | 53              | 66                                |

|                                            |                      |                          |
|--------------------------------------------|----------------------|--------------------------|
| 3-р шалгуур<br>Хөтөлбөрийн арга зүй        | 44                   | 64                       |
| 4-р шалгуур<br>Сургалтын<br>хэрэглэгдэхүүн | 30                   | 53                       |
| 5-р шалгуур<br>Хөтөлбөрийн үнэлгээ         | 15                   | 58                       |
| Дундаж оноо                                | 197 оноо<br>буюу 52% | 312 оноо<br>буюу 83 хувь |

#### Хүснэгт 3

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур

| Шалгуур                                                              | ӨМБИС<br>(оноо) | МУБИС    |
|----------------------------------------------------------------------|-----------------|----------|
| 1-р шалгуур<br>хөтөлбөрийн төлөвлөлт,                                | 49              | 58       |
| 2-р шалгуур<br>хөтөлбөр хэрэгжүүлэх<br>орчин, технологийн<br>нөхцөл, | 45              | 46       |
| 3-р шалгуур<br>сургалтын үйл ажиллагаа                               | 51              | 54       |
| Дундаж оноо                                                          | 145 оноо        | 158 оноо |

| Шалгуур                                                              | ӨМБИС<br>(оноо) | Сайжруулсан<br>хөтөлбөр (оноо) |
|----------------------------------------------------------------------|-----------------|--------------------------------|
| 1-р шалгуур<br>хөтөлбөрийн<br>төлөвлөлт,                             | 49              | 58                             |
| 2-р шалгуур<br>хөтөлбөр<br>хэрэгжүүлэх орчин,<br>технологийн нөхцөл, | 45              | 46                             |
| 3-р шалгуур<br>сургалтын үйл<br>ажиллагаа                            | 51              | 56                             |
| Дундаж оноо                                                          | 145             | 160                            |

ӨМБИС хөтөлбөрийн боловсруулалтын чанарын үнэлгээний үр дүнгээс харахад хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн (16%), хөтөлбөрийн үнэлгээнд (9%) бага ач холбогдол өгч, хангалтгүй боловсруулсан байна. 5 шалгуур, шалгуур бүрд 3 дэд үзүүлэлт бүхий 15 үзүүлэлт, нийт 75 үзүүлэлтийн сайжруулах шаардлагатай гэсэн 42 үзүүлэлтийн 10 нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал, 5 нь турших боломжтой, 25 үзүүлэлтийг сайжруулсан. Хөтөлбөрийн боловсруулалтын чанарын үнэлгээгээр үнэлж сайжруулсны үр дүнд уртын дууны хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт 24% сайжрах



боломжтой. МУБИС-ийн хөтөлбөрийн хувьд олон улсын стандарт шаардлагын түвшинд шинэчлэгдэж байгаа тул үзүүлэлт харьцангуй өндөр гарсан тул хүчин зүйлийн шинжилгээний үзүүлэлтийн ӨМБИС хөтөлбөрийн хүрээнд хийв. Учир нь 2014 онд хөтөлбөрийн ерөнхий хороо, хөтөлбөрийн салбар хороо, дэд хороо гэсэн хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлтийг чанар үр дүнг удирдан чиглүүлэх, хянан зохицуулах чиг үүрэг бүхий нэгжүүдийг байгуул, ажилласан нь хөтөлбөрийн чанар, үр дүн сайжрах нөхцөл болжээ. Тиймээс дутагдалтай олон шалгуур байгаа тул ӨМБИС-ийн хөтөлбөрийн хүрээнд хүчин зүйлийн шинжилгээг санал болгож буй хөтөлбөртэй харьцуулах байдлаар харуулав.

### Өгөгдлийн боловсруулалт, шинжилгээ

Судалгаанд хамрагдсан ӨМБИС-ийн хөтөлбөрийн хувьд дунджаар 2.28 (стандарт хазайлт нь 1.681), МУБИС-ийн хөтөлбөрийн хувьд дунджаар 3.47 (стандарт хазайлт 1.329), сайжруулсан хөтөлбөр нь дунджаар 4.19 (стандарт хазайлт 1.238) байсан.

Корреляцийн шинжилгээнээс үзэхэд ӨМБИС, МУБИС-ийн хөтөлбөр нь 0.661 буюу хамааралтай, ӨМБИС, сайжруулсан хөтөлбөр нь 0.475 буюу сул хамааралтай мөн МУБИС, сайжруулсан хөтөлбөр нь 0.489 сул хамааралтай байна.

| Корреляци            |                     |        |        |                      |
|----------------------|---------------------|--------|--------|----------------------|
|                      |                     | ӨМБИС  | МУБИС  | Сайжруулсан хөтөлбөр |
| ӨМБИС                | Pearson Correlation | 1      | .661** | .475**               |
|                      | Sig. (2-tailed)     |        | .000   | .000                 |
|                      | N                   | 75     | 75     | 75                   |
| МУБИС                | Pearson Correlation | .661** | 1      | .489**               |
|                      | Sig. (2-tailed)     | .000   |        | .000                 |
|                      | N                   | 75     | 75     | 75                   |
| Сайжруулсан хөтөлбөр | Pearson Correlation | .475** | .489** | 1                    |
|                      | Sig. (2-tailed)     | .000   | .000   |                      |
|                      | N                   | 75     | 75     | 75                   |


\*\* . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

ӨМБИС, МУБИС, сайжруулсан хөтөлбөрүүд нь бие биеэсээ хэрхэн ялгаатай байгааг хосолсон t- шалгуур (Paired t-test)-ын аргаар шалгаж үзэхэд ӨМБИС, МУБИС хөтөлбөрийн хувьд  $t=-8.024$ ,  $p=0.000$ ; ӨМБИС, сайжруулсан хөтөлбөрийн хувьд  $t=-10.696$   $p=0.000$ ; МУБИС, сайжруулсан хөтөлбөрийн хувьд  $t=-4.795$ ,  $p=0.000$  гарсан. Эндээс хөтөлбөрүүд хоорондоо статистикийн ач холбогдол бүхий ялгаа байна.


|        |            | Paired Differences |                |                 |                                           |        | t       | Sig. (2-tailed) |
|--------|------------|--------------------|----------------|-----------------|-------------------------------------------|--------|---------|-----------------|
|        |            | Mean               | Std. Deviation | Std. Error Mean | 95% Confidence Interval of the Difference |        |         |                 |
|        |            |                    |                |                 | Lower                                     | Upper  |         |                 |
| Pair 1 | ovor - mo  | -1.187             | 1.281          | .148            | -1.481                                    | -.892  | -8.024  | .000            |
| Pair 2 | ovor - sai | -1.907             | 1.544          | .178            | -2.262                                    | -1.551 | -10.696 | .000            |
| Pair 3 | mo - sai   | -.720              | 1.300          | .150            | -1.019                                    | -.421  | -4.795  | .000            |

Хөтөлбөрийг хэмжих, үнэлэх үндсэн хүчин зүйлүүдийн хамаарлын шинжилгээ (Фактор анализ), хамаарлын тоон загварыг гаргасан. Үүнд AMOS программ ашигласан бөгөөд ӨМБИС, МУБИС, сайжруулсан хөтөлбөрүүдийг шууд хэмжигдэх боломжтой хувьсагч гэж үзэн тэгш өнцөгт дүрсээр

харин шууд хэмжигдэх боломжгүй хувьсагчийг дугуй дүрсээр төлөөлүүлэн хамаарлыг тооцож гаргасан.



Хөтөлбөрийг сонгон авч ӨМБИС, МУБИС, сайжруулсан хөтөлбөрүүдийг хэмжин түүнийг хэмжигдэхүйц хувьсагчуудыг тодорхойлов. ӨМБИС-ийн хөтөлбөр 1.34, МУБИС-ийн хөтөлбөр 1.09, сайжруулсан хөтөлбөр 0.73 байгаа нь хөтөлбөрийг хэмжих үндсэн хувьсагч буюу шалгуур үзүүлэлт ач холбогдолгүй байна. Иймд сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагаар хэмжиж үзэв.



Дээрх хэмжилтийн үр дүнгээс үзэхэд ӨМБИС-ийн хөтөлбөр 0.35, МУБИС-ийн хөтөлбөр 0.45, сайжруулсан хөтөлбөр 0.45 байгаа нь хөтөлбөрийг хэмжих үндсэн хувьсагч буюу шалгуур үзүүлэлт болж байна.

### Дүгнэлт

Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн “дуу хөгжим” болон Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн “багш, урлагийн боловсрол” бакалаврын түвшний мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрүүдийг сонгон авч сургалтын болон хичээлийн хөтөлбөр талаас нь харьцуулан судалсны үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

- Сургалтын хөтөлбөрүүдийн кредитийн хувьд нэлээд зөрүү гарч байна. Тухайлбал, ӨМБИС-ийн хөгжмийн боловсролын бакалаврт суралцагч нь нийт 140 кредит судалж байхад МУБИС-ийн суралцагч нийт 124 кредит судалдаг байна. Кредитийг задалж авч үзвэл ӨМБИС-д заавал судлах кредит 98 бол МУБИС-д 114 кредит буюу 16 кредитийн зөрүү, харин ӨМБИС-д сонгон суралцах кредит 42 бол МУБИС-д 10 кредит буюу 32 кредитийн зөрүүтэй байна. Эндээс үзэхэд ӨМБИС-д хөгжмийн мэргэжлийн чадвар олгох хичээлүүдийн цаг МУБИС-иас 16 кредитээр илүү байгаа нь мэргэжлийн чадвар олгох цаг илүү төлөвлөгдсөн хэмээн үзэж болно.
- Хөтөлбөрийн чанарыг хэмжээсжүүлэн үнэлэх шалгуурын дагуу үнэлэхэд хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, аргазүй хамаарал ойролцоо үнэлэгдэж байхад сургалтын үнэлгээ, хөтөлбөрийн хэрэглэгдэхүүний үнэлгээ сул байгаа нь багш нар сургалтын хөтөлбөр боловсруулахдаа сургалтын хэрэглэгдэхүүн үнэлгээг чухалчлан үзэж сайжруулж боловсруулж байх шаардлагатай байна. Өнөөдөр их сургуулиуд зөвхөн хөтөлбөрийн төлөвлөлтөд анхаарч цаасан дээр хөтөлбөрөө боловсруулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх (сургалтын өдөр тутмын хяналт, багшийн заах арга зүй), төлөвлөж, хэрэгжүүлж буй хөтөлбөрийг оюутан хэрхэн эзэмшсэнийг үнэлэх үнэлгээ хоёрыг орхигдуулах хандлагатай байна хэмээн дүгнэж байна.
- Дуу хөгжмийн хичээлийн хөтөлбөрийн шинэчилсэн хувилбарыг боловсруулж чанарын 5 шалгуур, шалгуур бүрд 3 дэд үзүүлэлт бүхий 15 үзүүлэлт, нийт

75 үзүүлэлтээр үнэлэхэд сайжруулах шаардлагатай гэсэн 42 үзүүлэлтийн 10 нь хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал, 5 нь турших боломжтой, 25 үзүүлэлтийг сайжруулах боломжтой болно.

- ӨМБИС, МУБИС, сайжруулсан хөтөлбөрүүд нь бие биеэсээ хэрхэн ялгаатай байгааг хосолсон *t*-шалгуур (Paired *t*-test)-ын аргаар шалгаж үзэхэд ӨМБИС, МУБИС хөтөлбөрийн хувьд  $t=-8,024$ ,  $p=0.000$ ; ӨМБИС, сайжруулсан хөтөлбөрийн хувьд  $t=-10,696$   $p=0.000$ ; МУБИС, сайжруулсан хөтөлбөрийн хувьд  $t=-4,795$ ,  $p=0.000$  гарсан. Эндээс хөтөлбөрүүд хоорондоо статистикийн ач холбогдол бүхий ялгаа байна.
- Хөтөлбөрийг хэмжих, үнэлэх үндсэн хүчин зүйлүүдийн хамаарлын шинжилгээ (Фактор анализ), хамаарлын тоон загварыг гаргасан. Үүнд AMOS программ ашигласан бөгөөд ӨМБИС, МУБИС, сайжруулсан хөтөлбөрүүдийг шууд хэмжигдэх боломжтой хувьсагч гэж үзэн тэгш өнцөгт дүрсээр харн шууд хэмжигдэх боломжгүй хувьсагчийг дугуй дүрсээр төлөөлүүлэн хамаарлыг тооцож гаргасан. Хөтөлбөрийг сонгон авч ӨМБИС, МУБИС, сайжруулсан хөтөлбөрүүдийг хэмжин түүнийг хэмжигдэхүйц хувьсагчуудыг тодорхойлов. ӨМБИС-ийн хөтөлбөр 1.34, МУБИС-ийн хөтөлбөр 1.09, сайжруулсан хөтөлбөр 0.73 байгаа нь хөтөлбөрийг хэмжих үндсэн хувьсагч буюу шалгуур үзүүлэлт ач холбогдолгүй байна: Иймд сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагаар хэмжиж үзэв. Дээрх хэмжилтийн үр дүнгээс үзэхэд ӨМБИС-ийн хөтөлбөр 0.35, МУБИС-ийн хөтөлбөр 0.45, сайжруулсан хөтөлбөр 0.45 байгаа нь хөтөлбөрийг хэмжих үндсэн хувьсагч буюу шалгуур үзүүлэлт болж байна:
- ӨМБИС-ийн сургалтын хөтөлбөр нь бүтцийн хувьд харилцан адилгүй боловсруулагдсан, суралцахуйн үр дүнг тодорхой тусгаагүй. Хөтөлбөрийг боловсруулахдаа зөвхөн тухайн судлагдахууны хувьд мэдлэг, чадварыг тодорхойлоод иргэн, хувь хүний хөгжил талаас нь харьцангуй бага тусгасан байна. Цаашид сургалтын хөтөлбөрт оюутны мэдлэг чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний нийтлэг арга зүйг нарийвчлан боловсруулан тусгах шаардлагатай хэмээн үзэж байгаа болно.

## Ном зүй

- Даваа, Ж. (2012). *Их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөр боловсруулах аргазүй*. Улаанбаатар
- Дуламсүрэн, Ж. (2018). Сургалтын хөтөлбөрийн хэмжүүр бүтээх судалгаа. /онол, аргазүй/. *Докторын диссертаци*. Улаанбаатар.
- Лувсандорж, Ц., Дуламсүрэн, Ж. (2018). *Их Сургуулийн багш*. Улаанбаатар.
- МУБИС-ийн багшийн сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн ажлын тайлан. (2018). *Хөтөлбөр суурьтай хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн*. Улаанбаатар
- ӨвөрМонголын Багшийн Их Сургууль. (2016). *Хөгжим судлалын бакалаврын сургалтын хөтөлбөр*. Хөххот



**Music bachelor's degree curriculum some of the results of the study have been developed**  
(Program example on Mongolia Normal University of Education and Inner  
Mongolian Teachers University)

Mandulatu.E<sup>a</sup>, Shiilegmaa.Ya<sup>b\*</sup>

<sup>a</sup>Department of songs, School of Art,  
Inner Mongolia Normal University

<sup>b</sup>Office of research and innovation,  
Mongolian National University of Education

---

**Abstract**

There is needs to develop, evaluate, implement, and maintain a policy on all levels of music education curriculum on scientific basis. In this sense, modern theory education streams and values should be considered in determining the purpose, structure and content of the curriculum, or evaluating how the program is based on the philosophy of flow. We studied the bachelor degree of of music the Mongolian National University of Education and Inner Mongolian Teachers University at the level of the document and we identified the features, opportunities and advantages of the two programs, and identified strategies for mitigating weaknesses and risks. The purpose of the project was to develop and test. to evaluate the program's theories, methodologies and trends, develop a model and methodology for evaluating the program, compare comparative concepts of both programs and comparative research and evaluation, and evaluate and evaluate the learning outcomes of both music learning outcomes and outcomes, comparative analysis of content and methodology, evaluation system and evaluation of results, quality assurance systems, comparisons of how the program is reflected in the document, research and development of strategies to improve the vulnerabilities and risks, to develop strategies and opportunities to improve their opportunities and advantages. We examine the policies, decrees, orders, concepts of the program, program objectives, principles of the school and department's policies, and the relevance of current global approaches to the curriculum development of two universities, defined. We conduct a comparative study of the music program in the above universities, and here we state the features and various aspects of their principles, the similarity of their lines in concepts.

**Keywords**

Music education, knowledge, skills, development, results, curriculum, learning outcomes, assessment, standard

---



---

\* Corresponding author: Shiilegmaa@msue.edu.mn